

ХАР-УС НУУРЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАРТ ӨВӨЛЖИЖ БУЙ УСНЫ ШУВУУДЫН СУДАЛГАА

Дамдингийн Эрдэнэчимэг¹, Дарьсүрэнгийн Чинбат¹, Азвааны Хашбаатар¹, Баатарын Мөнхдалай¹, Лхагвагын Бэлэгдэмбэрэл¹, Бямбажавын Болд¹

¹Хар-Ус Нуурын Байгалийн Цогцолборт Газарын Захиргаа

харилцах хаяг: *chimgeed22@yahoo.com*

хураангуй. Бид 2013 оны 12 сард Хар ус нуурын БЦГ-ын нутаг дэвсгэр дэхь хөлдөөгүй задгай усан сангуудаар явж өвөлжиж байгаа шувуудын тооллого хийлээ. Судалгааны явцад 4 зүйлийн нийт 549 бодгаль тоолсон бөгөөд үүнд гангар хун 112, хумхин бохио 94, алаг шунгаач 292, мөн бор нугас 1 тус тус тоологдов. Өвөлжиж буй шувууд Чоно харайхын гол, Хомын хоолой, Цахиуртын хоолой, Тээлийн хоолой, Юмын хоолойд таарсан. Энэ нутгийн өвөлжиж буй усны шувуудын тооллого мониторинг судалгааг тотмолжуулах хэрэгтэйг зөвлөж байна.

түлхүүр үг: Усны шувуу, Хар ус нуур, өвлийн судалгаа

abstract. We carried out wintering waterbirds surveys in Khar Us Lake National Park in December 2013. We recorded a total of 549 individuals of 4 species of water birds, the whooper swan – 112, common merganser – 94, common golden-eye – 292, and the gadwall – 1. The wintering water birds were recorded along the Chono Kharaiikh River, Khomiin Tal, Tsakhiurtain Khoolooi, Teeliin Khooloi, and Ymiin Khooloi. We recommend that wintering water birds counts should be made every year.

keywords: wintering waterbirds, Khar Us Lake, winter counts

Тоодог 2:41-43, 2016

Оршил

Хар-Ус Нуурын БЦГ нь 1997 онд УИХ-н 47-р тогтоолоор Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн сүлжээнд хамрагдсан. 1999 онд “Рамсарын конвенц”-ын жагсаалтанд бүртгэгдсэн. Монгол Алтайн уулсын салбар Жаргалант Хайрхан, Их Нууруудын хотгорын томоохон нуурууд болох Хар-Ус, Хар, Дөргөн нуурууд, тэдгээр нууруудад цутгах голуудын цутгал хэсгийг хамарсан нийтдээ 850,272 га газар нутагтай (Гантөгс нар 2006, Чимэд-Очир нар 2006).

БЦГ дахь нуурууд цэнгэг устай, төрөл бүрийн усны ургамал элбэгтэй учир усны амьтдын бүлгэмдэлд таатай нөлөө үзүүлдэг онцлогтой. Нуур, ус намгархаг газруудтай зэрэгцэн хад, чулуутай өндөр уул, цөлөрхөг хээр зэрэгцэн оршиж байгаа нь амьтны аймгийн хувьд нэн баялаг байх үндэс болж байна. Цогцолбор газарт судлаачдын хийсэн судалгааны үр дүнг нэгтгэн үзэхэд 54 зүйл хөхтөн, 268 зүйл шувууд, 455 зүйл ургамал, 4 зүйл загас, 6 зүйл мөлхөгч, 131 зүйл шавж бүртгэгдсэн байна (Гантөгс нар, 2006).

Өмнө хийсэн судалгаагаар Хар ус нуурын

БЦГ-т хэд хэдэн зүйлийн усны шувууд тогтмол олон тоотойгоор өвөлждөг болох нь тогтоогдосон (Дуламцэрэн 1967, Batbayar 2002). Хэдий тийм боловч сүүлийн арав гаруй жил өвөлжиж байгаа шувуудын бүртгэл огт хийгдээгүй байна. Иймээс өвөлжиж байгаа шувуудын тоо толгойг хянах, хамгаалал, менежментийн ажил хийх шаардлагатай.

Бид Хар-Ус Нуурын БЦГ-ын харз усанд өвөлжиж байгаа усны шувуудын тоог тогтоох, цаашид хамгаалах менежментийн арга хэмжээг тогтоох зорилгоор өвлийн судалгаа хийлээ. Энэ судалгаа нь БЦГ-ын Хамгаалалтын захиргаанаас санаачилага гаргаж өвөлжиж буй усны шувуудын судалгааг дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар өөрсдийн бололцоогоо ашиглан анх удаа бие даан хийж байгаагаараа онцлог юм.


Арга зүй

Бид өвөлжиж байгаа усны шувуудын судалгааг 2013 оны 12-р сарын 19-с 9 хоногийн хугацаатайгаар ажиглалт хийж шувуудыг бүртгэлээ. Судалгаанд Хар-Ус Нуурын БЦГ-

ын хөлдөөгүй харз устай газрууд хамрагдсан. Судалгаанд яндан дуран болон хоёр нүдний дуран ашиглаж шувуудыг холоос ажиглаж зүйлүүдийг таних ажил хийв. Мөн Зүүн Азийн (Brazil 2009) болон Европийн (Mullarney *et al*, 1999) шувуудыг таних номуудыг ашиглаж усны шувуудыг тодорхойлсон. Шувуу тооллогын дүнг нэгтгэн хүснэгтэд оруулан ерөнхий анализ хийсэн.

Үр дүн

Судалгааны явцад бид нийтдээ 4 зүйлийн (гангар хун *Cygnus cygnus*, бор нугас *Anas strepera*, алаг шунгаач *Vulpes clangula*, хумхин бохио *Mergus merganser*) усны шувууны 549 бодгаль бүртгэсэн. Эдгээрээс гангар хун 112, алаг шунгаач 292, бор нугас 51, хумхин бохио 94 тус тус тоологдов. Эдгээр шувуудыг Чоно харайхын гол, Хомын хоолой, Цахиуртайн хоолой, Тээлийн хоолой, Юмын хоолойд харилцан адилгүй тоотойгоор тэмдэглэсэн (Зураг 1).



Зураг 1. Хар-Ус Нуурын БЦГ-ын өвөлжиж буй усны шувуудын төлөв байдал

Дүгнэлт

Бидний энэ тооллогын дүнг 2002 онд хийгдсэн өвлийн судалгааны үр дүнтэй харьцуулахад гангар хунгийн тоо, хумхийн бохионы тоо, алаг шунгаачын тоо өөрчлөгдсөн байна. Харин өвөлжиж байгаа шувуудын байршлын хувьд өмнөхөөс өөрчлөгдөөгүй байна. Гэхдээ задгай байгаа усны нийт талбай хэрхэн өөрчлөгдсөн эсэхийг бид мэдэх боломжгүй байлаа.

Судалгааны хугацаанд зарим нэг газруудад уур манан ихтэй байсан болохоор зарим шувуудыг танихад бэрхшээлтэй байснаас гадна хөлдөөгүй

харз усанд ойртох боломжгүй байсныг дурдах хэрэгтэй. Гэвч бид энэ удаагийн судалгааг амжилттай хийж гүйцэтгэсэн гэж дүгнэж байна.

Хэлэлцүүлэг

Судалгааны үр дүнгээс үзэхэд ХУНЦБГ-т усны шувууд олноор өвөлжиж буй нь харагдаж байна. Үүнээс өвөлжиж буй усны шувуудын хувьд Дөргөний Юмын хоолой болон Чоно харайхын гол хамгийн таатай орчин үүсгэж байна.

Өвөлжиж буй усны шувуудын судалгааны үр дүн дээр үндэслэн бид дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд 1) өвөлжиж байгаа усны шувуудын судалгааг жил бүр тогтмол хийж байх, 2) өвөлжиж байгаа шувуудын тэжээлийн хүрэлцээг судлан тогтоох, шаардлагатай бол нэмэлт тэжээл өгөх, 3) харз ус хөлдсөн үед шувуудад ус задгайлах ажлыг тогтмол хийж байх, 4) өвөлжиж байгаа шувууны тооллогыг иргэдийн дунд сайтар сурталчилж сайн дурын шувуу ажиглагч нарыг тооллогын ажилд татан оруулах зэрэг болно.

Хар ус нуурын БЦГ байгуулагдахад байгаль орчны экологи, нийгэм, эдийн засаг, газарзүйн олон төрлийн судалгаа хийгдсэн байдаг. Харин усны шувуудын судалгаа 1995 (Bräunlich 1995) болон 1998 (Liegl 1998) онуудад уг нутгийг Рамсарын конвенцид бүртгүүлэх ажлын хүрээнд хамрагдан хийгдэж байжээ. Гэвч түүнээс хойш дорвитой судалгаа хийгдээгүй. Бид БОНХЯ, ТХНУГ-т усны шувууны иж бүрэн судалгаа хийлгэх санал хүргүүлсэн боловч хөрөнгө мөнгөний асуудал шийдэгдээгүй. Харин Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр 2015 онд усны шувуудын судалгаа хийгдээд байна (Амархүү нар 2015).

Хар ус нуурын БЦГ зэрэг усны шувууд ихтэй тусгай хамгаалалттай газруудын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарыг шувуу таниж тодорхойлох талаар түлхүү мэдлэг эзэмшүүлэх шаардлагатай байна. Учир нь экосистемийн хөдлөл зүйн нэг тод баримт нь усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны өөрчлөлт болно (Примак ба бусад 2003). Түүнээс гадна мэргэжилтнүүд, байгаль хамгаалагч нарын судалгааны багаж хэрэгсэл маш дутмаг байгаад онцгой анхаарал хандуулах цаг болжээ.

Талархал

Энэхүү судалгааг дэмжиж санхүүжүүлсэн Хар Ус Нуурын БЦГ-ын захиргаанд талархсанаа илэрхийлье. Өгүүллийг сайжруулахад үнэтэй зөвлөлгөө өгч, тусалсан ЗАСХТ-ийн захирал доктор Б.Нямбаяр, судлаач Б.Ариунбаатар нарт баярласанаа илэрхийлье.

Ашигласан бүтээл

- Баатарцогт, Ш. 1984. Хар ус нуурт усны шувууд амьдрах экологийн нөхцөлүүд. МУИС.
- Гантөгс, С., П. Магсаржав, А. Хашбаатар, С. Дашдарь, Н. Одончимэг, А. Броинлих, and Х. Юнгиус. 2006. Хар ус нуурын байгалийн цогцолборт газрын менежментийн төлөвлөгөө. Хар ус нуур орчмын УТХГ-ын хамгаалалтын захиргаа, ДБХС-ын Монгол дахь хөтөлбөрийн газар, Ховд.
- Дуламцэрэн, С. 1967. Хар ус нуурт хун, нугас өвөлждөг. БНМАУ-ын ШУА-ийн мэдээ 3.
- Примак Р.Б., Д. Батболд, Р. Самъяа, and Н. Батсайхан. 2003. Байгаль Хамгааллын Биологи, Улаанбаатар.
- Цэвээнмядаг, Н. 1979. Хар ус нуур, түүний орчмын шувуудын зүйлийн бүрэлдэхүүн, тархац. Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл 14:166-175.
- Чимэд-Очир, Б., О. Мөнхбат, and Г. Энхтайван, editors. 2006. Хар ус нуурын байгалийн цогцолборт газрын менежментийн төлөвлөгөө (2006-2010). Хар ус нуур орчмын УТХГ-ын Хамгаалалтын захиргаа, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Улаанбаатар.
- Batbayar, N. 2002. Wintering waterbirds in the Khar Us Nuur National Park in Mongolia. *Birds, amphibians and reptiles of Mongolia* 1:120-126.
- Batbayar, N., A. Braunlich, N. Tsevenmyadag, S. Shar, and S. Gantogs. 2007. Conservation of the critically endangered east-Asian population of Dalmatian Pelican *Pelecanus crispus* in western Mongolia. *BirdingASIA* 7:68-74.
- Brazil, M. 2009. *Birds of East Asia: eastern China, Taiwan, Korea, Japan, eastern Russia*. Princeton University Press, London.
- Gombobaatar, S. 2004. Wintering water birds (Anseriformes) and their conservation. Pages 187-201 in 2004 International symposium on migratory birds, Gunsan, Korea.
- Braunlich, A. 1995. Report on the first WWF-Expedition to the Great Lakes Basin, western Mongolia, May - July 1995, and preliminary recommendations for the establishment of a new protected area. WWF Project Office Mongolia, Ulaanbaatar.
- Liegl, C. 1998. Waterfowl in Har Us Nuur National park and at Ayrag Nuur (Western Mongolia). Report on two Expeditions in June and September 1998. WWF, Ulaanbaatar, Mongolia.
- Mullarney, K., L. Svensson, D. Zetterstorm, and P. J. Grant. 1999. *The Collins Bird Guide. The most complete field guide to the birds of Britain and Europe*. Collins.